



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/199

Чойр

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.3, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны “Аймгийн төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2022 оны 08 дугаар тогтоолын 02 дугаар хавсралтын 1.12, 2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн 2022 оны төсөвт тусгагдсан Сүмбэр суманд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалыг хавсралтаар баталсугай.


2.Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, санхүүжилтийн гүйцэтгэл, үе шатны ажил техник хяналтыг зохион байгуулах болон ашиглалтад хүлээн авах ажлуудыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Сүмбэр сумын Засаг дарга (Т.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТЗАМ

Аймгийн Засаг даргын 2022 оны 06  
дугаар сарын 27-ны өдрийн А/191  
дугаар захирамжийн хавсралт



**СҮМБЭР СУМАНД ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН АЖЛЫН ЖАГСААЛТ**

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян.төг/	2022 онд санхүүжих дүн /мян.төг/
1	Сүмбэр сум 1-р баг "Худалдаачны гудамжны тохижилтын ажил"	217,915.3	217,915.3
2	Эко Сүмбэр хотхоны гадна бохирын шугамын засварын ажил	19,500.0	19,500.0
	<b>Нийт</b>	<b>237,415.3</b>	<b>237,415.3</b>